

## ЭРДЭМ БҮХНИЙ СУУРЬ

Эрдмийн далай ачит багшийг

Эрхэмлэн шүтэх нь гэгээрлийн эхлэл

Эл учрыг ухан ухаарч

Их бишрэлээр шүтэхэд адисал!

Хүмүүн заяа нь гэгээрэх боломж

Хүссэн болгонд олдоход бэрх

Хором алдалгүй шимийг нь авах

Ховорхон тэмүүлэл төрөхөд адисла!

Хүн болж төрсөн заяа

Хөөс адил замхран одно

Үхсэний хойно ч нүгэл буяны

Үйл үр сүүдэр мэт дагана

Үүнийг ухаараад гэм бүхнээ

Өчүүхэн гэлтгүй тэвчин аргилгасаар

Сайн үйлийн чуулганыг бүтээх

Санамж сэрэмж төгсөхөд адисла!

Зовлон хэзээ ч дуусахгүй,

Жаргал хэрхэвч дүүрэхгүй

Зорго, бүтлийн зөрүүг сэхээрээд

Зөвхөн нирваанд тэмүүлэхэд адисла!

Сансараас гэтлэх санаагаар тэтгэгдсэн

Санамж, мэдэмж, сэрэмжээр амилсан

Шашны тулгуур санваар сахилыг

Сайн явдлын зүрхэнд адисла!

Зовнигч амьтад миний л адил

Зовлонгийн далайд тэлчлэхийг хараад

Бусдыг аврах үүргийг тээгч

Бодь сэтгэлийг төрүүлэн адисла!

Энэрэл байвч гурван санваарыг

Эс бясалгаваас гэгээрэл бүтэшгүй

Сайтар мэдээд бодьсадвын санваарт

Сааршгүй хичээлээр шамдахад адисла!

Үймээнт сэтгэлийн цацралыг амарлиулж

Үнэн утгыг ёсчлон шинжилснээр

Дияан, билиг хослох ухамсрыг

Даруй сэтгэлд төрүүлэн адисла!

Эдгээр ухааны сав болвоос

Эрхэм төрөлхтний орох орц

Үлэмж дээд Очирт хөлгөнд

Үтэр түргэн ороход адисла!

Хоёр шидийг бүтээх суурь нь

Тангараг, санваар хэмээх зарлигийн

Чин үнэн утгыг олоод

Цэх шударгаар сахихад адисла!

Тантрын аймгийн хоёр зэргийн

Онсь утгыг ёсчлон онож

Дөрвөн хуваарьт иогийн явдлаар

Дээдсийн зарлигийг бүтээхэд адисла!

Энэ мэт мөрийг үзүүлэгч ба

Эрхэмлэн бүтээгчдийн өлмий батжиж

Дотоод, гадаад тотгорын чуулган

Даруй түргэн амарлихад адисла!